

БАТЛАВ. “ГҮНИЙ-УС” ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ж.ЭНХЧИМЭГ

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Байгууллагын нэр		Хэсгийн нэр	
“Гүний-ус” ХХК		Инженер техникийн хэсэг	
Ажлын байрны нэр		Хавсран гүйцэтгэх ажил	Дугаар
Хөдөлмөр хамгааллын инженер		Эрүүл ахуйч	1
Шууд харьяалагдах ажлын байр		Шууд харьяалах албан тушаал	
Гүйцэтгэх захирал		Байгууллагын нийт ажилчид	
Ажлын байрны зорилго		Компанийн зорилт, эрхэм зорилгыг эрхэмлэн ажиллах	

Ажлын байрны үндсэн чиг үүрэг

1. Байгууллагаас зохиосон мэргэжлийн болон бусад арга хэмжээнд идэвхитэй оролцох, шаарлагатай тохиолдолд үйлдвэрийн аль ч объектод ажил амралтын ямарч нөхцөлд бэлэн байхын зэрэгцээ, ээлжийн амралтаа зохицуулан илүү цагаар ажиллах
2. ХХАА-ны үе шатны зааварчилгууд, нийтийн аж ахуйн салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, стандартыг ажилдаа мөрдлөг болгон осол, аваар зөрчилгүй ажиллах
3. Хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгыг мөрдөн ажиллах
4. Ажил үйлдвэрлэлийн технологийн горимыг хатуу баримталж, ажлын бүтээмжийг өндөр байлгах, ажлын цагийг баримтлах, ажлын байр орхин дур мэдэн орхих, чөлөө зөвшөөрөлгүй явах, ажил таслах, чөлөөний хугацаа хэтрүүлэх, ажилтан болон бусдад сөрөг нөлөөлөл учруулахгүйгээр ажиллаж, хөдөлмөрлөх
5. Үйлдвэрлэлийн осол, гэмтэлд өортөхгүй байхын тулд мөрдөж ажиллах “БҮҮ МАРТ-10” зарчмыг ажилдаа хэвшүүлж ажиллах
6. Өөрийн мэдлэг, мэргэшил, ур чадварыг байнга төлөвлөлтэйгээр хөгжүүлж, сорилын болон улирал тутамд зохион байгуулагдах мэргэжлийн, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шалгалтанд манлайлж ажиллах
7. Хууль журам, дүрэм, стандарт, заавар, зааварчилгыг уншин судлан, өөрийн болгож улирал тутам мэргэжлийн сургалт, шалгалтанд хамрагдаж ажиллах
8. Байнгын болон орон тооны бус комисс, ажлын хэсэгт ажиллах ба ажлын гүйцэтгэлийн хэрэгжилтийг ханган үр дүнг удирдлагад тайлагнаж, мэдээ тайланг гаргаж ажиллах
9. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах ба Цэвэр бохир усны техникийн бүлэг, Уст цэгийн хамгаалах бүлгийн бие бүрэлдэхүүнд бэлэн байхын зэрэгцээ хээрийн сургууль, дадлага сургууль, өндөржүүлсэн буюу онц байдал зарласан үед шуурхай арга хэмжээ авч, удирдлага, зохион байгуулалтаар хангагдан ажиллах
10. Учирч болзошгүй эрсдэлээс сэрэмжлэн, аюулыг мэдээлж, илэрсэн зөрчил, гэмтлийг тухай бүрт нь мэргэжлийн ажилчинаар засварлуулан ажиллах
11. Ажлын байран дахь цахилгааны болон галын аюулгүй байдлыг ханган ажиллах
12. Ажил үүрэг гүйцэтгэж буйгаа ээлжийн диспетчерт заавал мэдэгдэж, бүртгүүлж ажиллах

Ажлын байранд хийгдэх ажлууд:

1. Нийт ажилчдад болон үйлдвэрлэл дээр дадлага хийхээр ирсэн дадлагжигч, оюутанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, уралдаан тэмцээнд ажилтнуудыг хамруулах, сургалтыг зохион байгуулах
2. Эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилчдыг хамрагдсан эсэхэд хяналт тавьж ажиллах
3. Ажилчдын хоолны чанарт анхаарч илчлэг сайтай хоолоор шугам сүлжээний ажилчдыг хангах
4. Нийт ажилчдад ажлын байрны урьдчилсан, анхан шатны, өдөр тутмын буюу давтан зааварчилгыг тогтмол өгч, үйлдвэрлэлийн осолд өртөхгүй байх “БҮҮ МАРТ-10” зарчмыг мөрдүүлж осол аваараас урьдчилан сэрэмжилж ажиллах
5. Түрээсийн болон ажилчдын хөдөлмөр хамгааллын хамгаалах хэрэгсэл өвөл зуны нормын хувцасны захиалгыг бүрэн авч захиалгын дагуу биед нь таарсан, стандартын шаардлагыг хангасан хувцас, хамгаалах хэрэгсэл, хор саармагжуулах ундаагаар ханган ажиллах
6. Үйлдвэрлэл үйлчилгээний технологийн горим зөрчигдсөн тохиолдолд үйл ажиллагааг зогсоох, шуурхай арга хэмжээг зохион байгуулах тал дээр удирдлагаас шийдвэр авч ажиллах
7. Стандартын шаардлага хангасан ажлын тусгай хувцас, багаж хэрэгслээр хангаж, осол эндэгдлээс бүрэн хамгаалж ажиллах
8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн самбар, булан, кабинетийн ашиглалтыг сайжруулах, шинээр хийж баяжуулан ажиллах
9. Цэг салбарын үйл ажиллагаанд ариун цэвэр, эрүүл ахуйн болон ажлын байрны таатай орчинг бүрдүүлж ажиллах
10. Улиралд нэгээс доошгүй удаа ажилчдаас хөдөлмөр хамгааллын чиглэлээр шалгалт авч ажилчдын аюулгүй ажиллагааны мэдлэгийг дээшлүүлэх тал дээр анхаарч ажиллах
11. Шөнийн цагаар шугам сүлжээ, гэмтэл засварт ажиллаж байгаа ажилчдыг гэрэлтүүлэг болон зайлшгүй шаардлагатай хэрэгсэлээр хангах
12. Үйлдвэрлэл дээр ашиглагдаж буй тоног төхөөрөмж, багаж, тээврийн хэрэгсэлийн техник ашиглалтын паспорт, хувийн хэргийн дэвтэрийн тэмдэглэлд хяналт тавьж үүрэг даалгавраар ханган ажиллах
13. Багаж, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааварчилга, туршилт тохируулга болон ашиглагдахаар зөвшөөрөгдсөн эсэхэд ашиглалтын явцын шаардлага хангагдсанд удирдлагаас зөвшөөрөл авч хяналт тавьж ажиллах

Ажлын байранд тавигдах шаардлагууд:

Ерөнхий шаардлага	Мэргэжил	УХАТ инженер
	Боловсрол	Мэргэшсэн ба түүнээс дээш түвшин
		• Харилцааны болон хамтран ажиллах чадвартай

	Ур чадвар	- Мэдээ, мэдээллийг нэгтгэх, дүн шинжилгээ хийх чадвартай - Магистр болон түүнээс дээш мэргэжлийн түвшинд мэргэшсэн - Мэргэшсэн болон зөвлөх инженер - Удирдан зохион байгуулах чадвартай
Тусгай шаардлага		- Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд тогтмол хамрагдаж ажиллах - Эд хөрөнгө эзэмших гэрээг аж ахуйн няравтай байгуулж ажиллах
Ажлын байрны нөөц хэрэгсэл	Санхүү	- Албан тушаалын цалин, эрдмийн болон мэргэжлийн цол зэрэг, ур чадварын нэмэгдэл, бусад нэмэгдэл, нөхөн төлбөр, тусламж, тэтгэмж, урамшуулал, мэргэжлийн чиглэлээр сургалт, семинарт хамруулах - Монгол улсын хэмжээнд мөрдөж байгаа Засгийн Газраас тогтоосон Хөдөлмөрийн хөлсний өөрчлөлтийг мөрдөж ажиллах - Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалыг хариуцах
	Ажлын байр	- Хөдөлмөр хамгаалах хувцас, багаж хэрэгслээр хангах. - Ажлын өрөө, ширээ, сандал - Бичгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж - Ажил үйлчилгээний зориулалттай гар утас нэгж хариуцан ажиллана - Гэнэтийн ослын даатгалд даатгуулж ажиллана - Унаанд нь шатахуун /лимитээр/ олгоно.
Ажлын байрны нөхцөл: Хэвийн		
Ажлын байрны нэр: Хөдөлмөр хамгааллын инженер		

4. Ажлын байрны тодорхойлолт

Боловсруулсан:	Танилцсан:
Хүний нөөцийн менежер: /	Ерөнхий инженер: /С.Отгончулуун/